



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 02. 25 № 01/06 УАТ-ЛАТ/2013/01-СМА-ТМД

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.ГАНЦОГТ ТАНАА

Төсвийн орлого болгох тухай

Сангийн яамны аппаратын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газрын даргаар ахлуулсан шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулсан комиссын гишүүдэд 6,683.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон, Төрийн нарийн бичгийн дарга асан Д.Баттөр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байхад түүнд албан тушаалын 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 5,104.8 мянган төгрөг олгосон, яамны ажилтнуудад 19,980.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон зэрэг зөрчил илэрсэн нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д "Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т "Ажилтнуудад цалин хөлс, урамшуулал, тэтгэмж илүү олгосон"-д төлбөрийн акт тогтооно гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажилтнуудад цалин хөлс, урамшуулал, тэтгэмжээр илүү олгосон 31,768.0 мянган төгрөгийг 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Төв төрийн сан дах Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Дээрх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, ерөнхий нягтлан бодогч Б.Тамир нарт хариуцуулав.

АКТЫГ



070013